МЭДЭЭ · 2023 оны 1-р сарын 30

# АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН 8 ХЭРЭГТ ЯЛЛАХ ДҮГНЭЛТ ҮЙЛДЭН ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЭВ




Прокурорын байгууллага өнгөрсөн долоо хоногт буюу 2023 оны 1 дүгээр сарын 23-наас 27-ны өдрүүдэд хэрэг бүртгэлтийн 29.692, мөрдөн байцаалтын 2407 хэрэгт хяналт тавьж ажиллав.

Үүнээс Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 132, Өмчлөх эрхийн эсрэг 63, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 30, Хүрээлэн байгаа орчны эсрэг 9, Авлига албан тушаалын 8, Бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 7, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 2, Мөрийтэй тоглоом зохион байгуулах 1, нийт 264 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж шийдвэрлэлээ.

Яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн зарим хэргүүдийг дурдвал:

- Булган аймгийн Бугат сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлаар ажиллаж байсан А нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж тус сургуулийн 4 багшид үндэслэлгүйгээр ур чадварын нэмэгдэл олгон өөртөө авч, давуу байдал бий болгосон гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн Булган аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд;

- Булган аймгийн Орхон сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч Л нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж зөрчил шалган шийдвэрлэх

ажиллагааны явцад хураагдсан 259 кг хуш модны самрыг зохих байгууллагад шилжүүлэхгүйгээр худалдан борлуулж, бусдад давуу байдал бий болгосон гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн Булган аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд;

- Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргаар ажиллаж байсан Э, Хөдөлмөрийн эрхлэлтийн хэлтсийн дарга М нар нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулах ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан тэмдэглэл үйлдэж, сонгон шалгаруулалтгүйгээр бусад компанид давуу байдал олгон 90 сая төгрөг олгохоор шийдвэрлэсэн гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн, Хөвсгөл аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд;

- Иргэн Ө нь Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт мөрийтэй тоглоомын газар байгуулж, иргэдийн дунд мөрийтэй тоглоом зохион байгуулсан гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлийн 2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд тус тус шилжүүлсэн байна.

---

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2110